



“Япон-Монголын Бизнес уулзалт” зохион байгуулах тухай мэдэгдэл

Монгол Улсаас Япон улсад суугаа Элчин сайдын яам нь 12-р сарын 9-ний өдөр Токио хотноо “Инвест Монголиа” чуулга уулзалт зохион байгуулагдахтай холбогдуулан чуулга уулзалтын төлөөлөгч монголын хувийн хэвшлийн төлөөлөгчдөд зориулан 12-р сарын 10-ны өдөр Япон-Монгол “Бизнесийн мэдээлэл солилцох уулзалт”-ыг ЭСЯ дээр зохион байгуулахаар болов.

“Инвест Монголиа” чуулга уулзалтад оролцохоор Монгол Улсын Их Хурлын гишүүн болон Засгийн газрын холбогдох албан тушаалтан, хувийн хэвшил, бизнесийн байгууллагын төлөөлөл нийт 60 гаруй хүн Монгол Улсаас Япон Улсыг зорьж ирэх юм. Эдгээр төлөөлөгчид дунд уул уурхай, банк санхүү, үл хөдлөх хөрөнгө, худалдаа арилжаа, хөдөө аж ахуй зэрэг салбарыг хамарсан хувийн хэвшлийн 30 гаруй пүүс компаний төлөөлөл орж байгаа юм.

Энэ онд Монгол-Японы хооронд Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулагдаж, тун удахгүй хүчин төгөлдөр болох гэж байгаа нь хоёр орны худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөтгөн хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой юм. Иймд Япон Улсын бизнесийн салбарынхантай уулзаж, өөрийн пүүс компани, бизнес санал, төслөө танилцуулах боломж олгох үүднээс энэхүү мэдээлэл солилцох бизнес уулзалтад өргөнөөр оролцохыг урьж байна.

◆Огноо : 2015 оны 12-р сарын 10 (Пүрэв гараг)-ны өдрийн 14:00-17:00 (13:30-аас бүртгэл эхэлнэ)

◆Болох газар: Монгол Улсын Элчин сайдын яам (Токио хот, Шибуя дүүрэг, Камияма-чо 21-4) [Газрын зураг харгах](#)

◆Хөтөлбөр

14:00~14:20	Зохион байгуулагч болон хүндэт зочдын мэндчилгээ (Монгол Улсын УИХ-ын гишүүн, Монгол Улсын Элчин сайдын яам, Япон улс дахь Монгол Улсын Худалдаа аж үйлдвэрийн тэнхим, Фронтинер Секьюритиз компани)
14:30~17:00	Бизнесийн мэдээлэл солилцох уулзалт (Монгол компаниуд тусгай ширээн дээр сууж, өөрийн компанийн талаарх танилцуулгыг хийнэ)

※Бизнесийн мэдээлэл солилцох уулзалтын үеэр япон-монгол хэлний орчуулагч цөөн хэдхэн хүн ажиллах тул өөрсдөө орчуулагчаа бэлтгэх буюу дарааллын зарчмаар үйлчлүүлэхийг урьдчилан мэдэгдэж байна.

◆Гол зохион байгуулагч, хамтран зохион байгуулагч : Монгол Улсын ЭСЯ, Япон улс дахь Монгол Улсын Худалдаа аж үйлдвэрийн тэнхим, Фронтинер Секьюритиз компани

◆Хураамж: Үзэсгэлэн гаргагч болон хурлын төлөөлөгчид үнэ төлбөргүй

◆Бизнес уулзалтад чөлөөт оролцогчоор бүртгүүлэх: [Энэ холбоос дээр дарж онлайнгаар бүртгүүлнэ үү](#)
Чөлөөт оролцогч зааланд чөлөөтэй явж, хүмүүстэй нэрийн хуудас солилцож, босоо уулзалт хийх боломжтой.

◆Бизнес уулзалтад сурталчилгааны ширээ ашиглагчаар бүртгүүлэх: Дээрхи холбоос дээр дарж бүртгүүлэхээс гадна Компанийхаа 100-150 үгэнд багтсан танилцуулга, цахим хуудас, салбарын нэр зэрэг мэдээлэлээ 11-р сарын 27 ны дотор staff@frontier.mn хаягаар ирүүлнэ үү. Ширээний тоо хязгаартай байгаа тул / 40X160-ын ширээ 13, 80X160-ын ширээ 6 байгаа болно/ түрүүлж бүртгүүлсэн дарааллаар ширээ ашигласан сурталчилгаа хийх боломжтой болохыг анхаарна уу. Ширээ ашиглаж сурталчилгаа хийгч ширээн дээр тавих бага хэмжээтэй баннер авчирч болохоос гадна тараах материал, компанийн хэвлэмэл танилцуулга тодорхой тоо хэмжээгээр авчрах шаардлагатай. Ширээний ард 2 сандал тавьсан байх болно.

◆Бүртгүүлэх эцсийн хугацаа: 2015 оны 11-р сарын 30 (Даваа гараг)

◆Холбоо барих Фронтинер Секьюритиз (Хариуцсан хүн: Б.Бат-Эрдэнэ)

Утас: +976 99005654

И-мэйл:staff@frontier.mn

